

АНДАЙН ШҮТЛЭГ БИШРЭЛИЙН СОЁЛЫН УЧИР

Дархуд Хянган *

(Агуулгын товч) Андай бол монгол үндэстний бодасын бус соёлын нандин өв болно. Андайд монгол үндэстний язгуур үеийн олон төрлийн соёл урлагийн язгуур хэв, улбаа мөр уусан шингэж буй. Андайг бүхэл цогцоос нь үзвэл, тэр бол монголчуудын язгуур соёлын органик нийлэлцээ, язгуур соёлын ачаалагч мөн. Тус өгүүлэлд голдуу андайд агуулагдаж байгаа амьтны шүтлэг, модны шүтлэг, сүнсний шүтлэг, дом шүтлэг, бөөгийн шүтлэг зэрэг монголчуудын язгуур эртний шүтлэг бишрэлийн соёлуудыг өгүүлэв.

(Зангилагын үг) Андай, шүтлэг бишрэл, соёл

Андай бол монгол үндэстний язгуур соёлын нэг, бодисын бус соёлын чухал өв болно. Соёлын агуулгаас нь үзвэл андайд монголчуудын эртний соёл сэтгэхүй, үзэл ухамсар, шашин шүтлэг, зан үйл, анагаах ухаан, дуу бүжиг, утга зохиол, аман урлаг зэрэг олон янзын язгуур соёлын улбаа мөр уусан хадгалагдаж буй. Андайг эрдэм шинжилгээний хараагаас ажвал тэр нь утга зохиол урлагийн ухаан, соёл хүн судлал, нийгмийн ухаан, угсаатан зүй, шашин суртахууны ухаан, хүн соёлын газар зүй, анагаах ухаан зэрэг олон зүйлийн шинжилгээний салаатай холбогдоно. Иймээс андай бол нэгэн ерөнхийлсөн шинжтэй язгуур соёлын өв болно. Андайд агуулагдаж байгаа язгуур соёл үзэгдлийг судлан уудлах нь бүхүйлэн монгол соёл судлалд одооч ач холбогдлыг ханган өгч чадна гэж би санана.

Нэг. Амьтны шүтлэг

Андайд эртний монголчуудын амьтны шүтлэгийн улбаа мөр илхэн харагдана. Гэхдээ андайд гол илэрч байгаа амьтны шүтлэг бол элээ шүтлэг болон шар шувууны шүтлэг болно.

Одоохондоо болтол олдоод байгаа андайн хамаг эртний нэг хэлбэр бол “элээ андай” болно. Андайг түүхэн хөгжилтийн голт чиглэлээр нь үзвэл “элээ андай” бол алс эртний андайд харьяалагдаж андайн язгуур эртний язгуур хэвийнхэн нэг болно. Элээ бол “өвчин засах соёлт баатар”, “дуу бүжгийн соёлт баатар” болох мөртөө “элээний шүтлэг бол балар эртний эхийн эрхэт нийгмээс үүсэлтэй, эртний бүжиг, дуу, урлагтай барилдсан эртний хүмүүсийн овог аймгийн бүлэг цогцын ухамсар, үржил эснэлийн

* Өвөр Монголын Багшийн Их Сургууль

танилтыг тусган харуулсан соёлын бүтээгдэхүүн”¹ мөн. Судалгааныг үндэслэвэл, андай бол эхийн эрхт овог төрлийн үед үүсэв. “Элээ андай” бол голдуу Өвөрмонголын хүрээ хошуу, дархан хошуу, монголжин хошуу зэрэг газар орноор үлдээгдэж ирсэн андайн төрөл зүйл болох бөгөөд бас “цагаан элээ” гэж нэрлэдэг. “Цагаан элээ”-г голдуу эмэгтэй хүн дуулдаг. Зарим домогт цагаан элээг тэнгэрийн эхнэр, сахиус гэдэг бөгөөд “элээ андай”-н домгуудад элээ нь хааны хүүхнээр дүрслэгддэг. Андайд бас “Элээ андайн аймгууд аа, энх сэрүүлье ямар буй?”, “өв үнэн элээ угсаатан бол ам түргэн сэтгэл асвар юм” гэж дуулдаг. Энэ нь язгуур эртэндээ ямар нэгэн аймаг угсаа нь элээгээр сүлд шүтээнээ болгож байсныг харуулж буй. “Амьтан араатнаар овгийн нэрийдэл болгох явдал овгийн байгуулалын үүслийн үе, даруй эхийн эрхт овог төрлийн үед түгээмэл оршиж байсан үзэгдэл болно. Тэр үед сүлд шүтээн нь овог аймгийн нэр, тэмдэг болж байсан бөгөөд овгийн гишүүн нэг бүрийн хувийн нэр болж байв”². “Элээ бол эм хүйстэний тусгай сахиус, охин онгод эм сахиус, түүний язгуур дүр нь монголын эхийн эрхт нийгмийн үеэс үүсэлтэй дуу бүжиг урлагийн онгод сахиус болно”³.

Дүгнэж хэлбэл, элээ бол ямар нэгэн аймаг угсаатны онгон шүтлэг байсан нь илэрхий. Энэ нь балар эртний сүлд шүтээн шүтлэгтэй холбогдох бөгөөд амьтны шүтлэгийн нэг болох элээ шүтлэгийн үзэгдэл болно. “Элээ андай” бол эхийн эрхтийн овог төрлийн үед үүсэв. Гэхдээ тэр нь ямар нэгэн овогтны элээ шүтлэгийн суурин дээр үүсэв. Элээ шүтлэг нь андайн үүсч бүрэлдэхэд шүтлэг соёлын үндэс болов. “Элээ андай нь анх эхэндээ шүтээн шувуун шинжтэй таашаалын утгатай байсан буюу шүтээн шинж болон ад шинжийн нэгдмэл цогц байж, овог аймгийн дайн дажины үеэс эхлэн ад шинж нь улам нэг алхан чангарчээ”⁴. Элээ шүтлэгийн иймэрхүү хувиралт хөгжил нь үнэндээ эртний монголчуудын амьтны шүтлэгийн хувирал хөгжилтийг заан тодолж байдаг.

Монголчууд эртнээсээ шар шувуугаар элээ адыг үлдэн хөөх зан үйлтэй байсан бөгөөд шар шувуун шүтлэгтэй байжээ. “Шар шувуухай” гэх магтаал дуунд:

Зажин үсэн дамагтай
Жавар салхин хүлэгтэй
Хөнгэй модон хэвтэштэй
Хий салхин хүлэгтэй
Хотгор газар нутагтай
Хуй салхин эргэлгээтэй
Хулгана оготно идэштэй
Хорт могой зууштай
Харанхуй гялсах хараатай
Харгана боролж замтай
Харвах зэвийн бууцтай
Хутган мэст савартай
Эцэг тэнгэрийн элч

¹ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андаа товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 77-р тал.

² Хүрэлшаа: “Монгол домгийн соёл судлал”. Үндэстний хэвлэлийн хороо, 2004, 75-р тал.

³ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 75-р тал.

⁴ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 82-р тал.

Элээ адын дарлага⁵ гэж шар шувууны амьдарч орших зан араншинг тодорхойлон танилцуулж байгаа бөгөөд түүнийг “эцэг тэнгэрийн элч, элээ адын дарлага” гэж магтан дуулж байдаг. Үүнд, монголчуудын эртний шар шувуун шүтлэгийн соёл ухамсар илэрч буй. “Ууль шувууны амьтны зүйн өвөрмөц онцлог нь эртний хүмүүсийн ууль шувууны шүтлэг, ууль шувуугаар ад чөтгөрийг үлдэх эчнээ ойлголтын нэгэн үндэс болсон юм. Үүний улмаас эртний монголчуудын ойлголт, бөө мөргөлийн үзэлтэд ууль шувуун шүтлэг, ууль шувуугаар ад чөтгөрийг дардаг ухамсар буй болсон байна хорчинд шар шувууг бас ууль гэдэг”⁶. “Андай дуулахад шар шувуугаар элээ адыг дарангуйлдаг нь эртний монголчуудын шар шувууны шүтлэг, бөө мөргөлийн шар шувуухайн шүтлэг бишрэлтэй холбоотой”⁷. “Бөө удганууд онгод их хилэгнэх үед гадуур шар шувуу ирж хүүхлэнэ хэмээн үздэг. Ер нь бөөгийн онгод шар шувуунд хувилан үзэгдэх ёс бий гэх бөгөөд бөөгийн онгодын мэргэн хурц зөн билгийг агуулан хадгалагч гэж үздэг”⁸. Монгол улсын Хөвсгөл аймгийн удган Энхтуяагийн нэгэн онгод бол даруй шар шувуу болно. Тэр надад шар шувуугаар ад чөтгөрийг дардаг гэж ярьж өнгөрөв⁹. Андайд эртний амьтны шүтлэгийн нэг болох шар шувуун шүтлэг тодорхой илэрч буй. Гэхдээ шар шувуун шүтлэг нь нийгмийн хувисалт, хүмүүсийн шар шувуунд хандах үзэлт танилтын хувиралтыг дагалдан хувирч хөгжиж ирсэн байдаг. Энэхүү хувиралт нь андайд бодит тусгалаа олж буй. “Бөөр хийе” гэдэг андай дууд:

Хар ууль донгодох чинь
Харшил ирэхийн ерөөл шүү
Харагч гүү унагалах нь
Харшил арилахын тэмдэг ээ
Шар ууль донгодох чинь
Шалтаг болохын ерөөл шүү
Шар ингэ ботголох чинь

Саад арилахын тэмдэг ээ¹⁰ гэж дуулдаг. Үүнд, ууль шувууны дуу нь харшил зовлонгийн бэлэг тэмдэг болж шар шувуу нь “Язгуур монголчуудад “адын дарлага” шүтээн шувуугаар шүтэгдэж байснаа бурхан шашин монголд дэлгэрэхийг дагалдан бэлэг муутай, муу ерөөлтэй шувуу хэмээгдэх”¹¹ болсон шар шувуун шүтлэгийн хувиралт тодорхой тусгагдаж буй.

Тус хэсгийг хураангуйлбал, андайд эртний монголчуудын амьтны шүтлэг, онцгойлон шувуун шүтлэг (элээ шүтлэг болон шар шувуун шүтлэг) болон түүний хувиралт хөгжил бодитой илэрч буй. Амьтны шүтлэг нь элээ андай буюу бүхийл андайн үүсч бүрэлдэхэд соёлын шимт хөрс болж өгөв.

Хоёр. Модон шүтлэг

Эртний монголчууд саглагар мод, хос мод, уд улиас, бургас, нарс майлс, хайлаас, зандан зэрэг олон зүйлийн модыг шүтдэг. Энэ нь эртний монголчуудын түмэн бодос

⁵ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 361-р тал.

⁶ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андаа товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 104-р тал.

⁷ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андаа товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 105-р тал.

⁸ С.Дулам: “Монгол бэлгэдэл зүй”, дөтгөөр дэвтэр, Улаанбаатар, 2007, 133-р тал.

⁹ Дархун Хянгану сурвалжлага, 2015 оны 06 сарын 19 өдөр

¹⁰ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 295-р тал.

¹¹ Хүрэлшаа: “Монгол домгийн соёл судлал”. Үндэстний хэвлэлийн хороо, 2004, 237-р тал.

бүр сүнстэй гэсэн ойлгодохуунаас ирэлттэй. Иргэншлийн шүтлэг бишрэлийг голт хөгжилтээс нь үзвэл байгалийн шүтлэг, тотем шүтлэг, дээдсийн шүтлэг гэж хувирч улирч ирсэн төлөвтэй. Эртний монголчуудын модон шүтлэгийн хөгжил хувирал нь иргэншлийн шүтлэг бишрэлийн энэхүү түүхэн явцтай нийцэж байдаг. Цоросчууд өөрийгөө “ур модон эхтэй, ууль шувуун эцэгтэй” гэж хэлдэг. Халимагчуудын дээдсийг “уд модон эхтэй” гэж хэлдэг бөгөөд халимагчуудын дунд өөрсдийнхөө дээдсийг модноос төрж модны шим шүүсийг хөхөж бойжлоо гэсэн домог дэлгэрсэн байдаг. Хорчинд, хүн нас барсны сүүлээр гэрийнхэн хүмүүс нь хос алд урт модон салаа бэлэгдэж энэхүү модон салааныхаа үзүүрт нь маанийн үсэг бүхий дарцаг өлгөнө. Үүнээ тэд “сүнс даллах мод” гэдэг. Хөдөөлүүлэх өдөр нас барсан хүний их омбол хүү нь энэхүү сүнс даллах модоо барин авс дамнагчдын хамаг өмнө нь явна. Хөдөөлүүлж барсны дараа энэхүү сүнс даллах модоо онгоныхон ар хормойд нь хатгаж тавина. Хэрвээ энэ мод нь эдгээрхид хүрвэл нас нөхцигчийн гэр бүлийнхэн ихээр баярладаг. Энэхүү зан үйлд модонд сүнс оршдог гэдэг эртний модон шүтлэгийн соёл ухамсар тодорхой илэрч байгаа бөгөөд дээдсийнхээ сүнсийг мод шиг өнө удаан эснэл амилалтай байж үе хойчисыгоо хэзээд ивээн тэтгэхийг бэлгэдэн хүссэн санаа сэтгэлгээ агуулагдаж буй. Монголчуудын модон шүтлэг нь монголчуудын олон зүйлийн язгуур соёлыг ачаалж хадгалж ирсэн соёлын нандин өв болох андайд ч өөрийнхөө тусгалаа олж буй.

Андайд, хонх ташуураар элээ адыг үлдэн хөөх зан үйл байдаг. Хонх ташуурын ишийг нь сухай модоор хийдэг бөгөөд ишийнхэн үзүүрт нь хоёр хүрэл толь, хоёр гуулин хонх уядаг. “Монголчууд сухай модыг бас шүтдэг. Өнгө улаан маш хатуу модыг сухай мод хэмээдэг”¹². “Энэ мод нь албиныг зайлуулах дом буй хэмээмүй”¹³, “сухай ташуурыг бөөгийн шүтлэгэд чөтгөр цохих ташуур гэнэ”¹⁴, “Хорин нэгт тайлбар толь”-д сухай модыг “Уд модтой адилхан болоод маш хатуу, өнгө улаан, ишээр нь ташуурын иш хиймүй. Боос гүүг цохивоос унага орхимой хэмээмүй”¹⁵ гэж тайлбарлаж буй. Сухай мод нь улаан өнгөтэй. “Хар өнгө болон улаан өнгө, тус хоёр өнгө нь ад чөтгөрийг үлдэн хөөдөг”¹⁶. Эдгээрээс үзэхүл, эртний монголчууд сухай модыг шүтдэг байжээ. Монголчууд олон төрлийн модыг шүтэхдээ тэдгээр модны бэлэгдэл шинж, амьжирлын хүч, өнгө дүрс, чанар чансаа, ашиг хэрэгцээ зэрэгт нь тохируулан шүтдэг. Тэд үржил эснэл бүлгэмдэл нягтрал, амь амьжирлын ойлголтоосоо болж ой шугуй болон саглагар модыг шүтдэг. Амьжирлын хүчнийг нь гайхан бишрэхдээ хээр талд гагцаар ургадаг модыг шүтэн тахидаг. Өнө мөнх хөхөрдгөөр нь амь насны бэлэгдэл болгож нарс майлсыг шүтдэг. Бuzар буртгийг үлдэж анхилам үнэрийг авчирдгаар нь зандан модыг шүтдэг. Сухай модыг шүтэн биширдэг нь харин түүний чанар нь хатуу, өнгө нь улаанаас болов.

¹² Хүрэлшаа, Саруул: “Монгол соёл судлалын цуврал бичиг, зан үйл” (дээд). Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2003, 94-р тал.

¹³ “Хорин наймт тайлбар толь”. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1399-р тал.

¹⁴ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 94-р тал.

¹⁵ “Хорин нэгт тайлбар толь”. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1979, 586-р тал.

¹⁶ Шүхуа лун: “Дундад улсын чөтгөрийн соёл”, Шанхайн утга урлагийн хэвлэлийн хороо, 1990, 216-р тал.

Хураангуйлбал, бодосын бус соёлын өв андайд, монголчуудын язгуур эртний байгаль шүтлэгийн нэг болох модон шүтлэг – сухай модон шүтлэгийн тухай үзэлт ойлгогдохуун илэрнэ.

Гурав. Сүнсний шүтлэг

Андайд эртний монголчуудын сүнсний тухай шүтлэг бишрэл, сүнсний тухай ойлгогдохуун илэрдэг. Андайд хүмүүс ердөө сүнсний өвчин гэдэг. Өөрөөр хэлбэл муу сүнсний хорлолоос болоод сая хүмүүс андай өвчин олдог гэж үздэг. Андайд:

Ширмэл ултай гутлаа
Ширгэж ортол дэвсье
Ширэлдээд салахгүй муу сүнснийг
Шилийн хуа давтал хөөе

... ..

Наамал ултай гутлаа
Нимгэртэл дэвсье
Нар үзэхгүй муу сүнснийг
Наашгүй болтол явуулья

... ..

Хайлаастайн асган зам
Харлана сайхан харагдана
Хорлох сүнсэд хууртагдаад

Хазгай бүү явцгаа даа¹⁷ гэж дуулдаг. Үүнд, андай өвчин бол муу сүнсний хорлолоос болов, муу сүнснийг нь зайлуулаад явуулбал сая өвчин нь илэрхий болно гэсэн санаа илэрч буй. Энэ нь яг саяхан балар эртний хүмүүсийн сүнс бол бусдад наалдаж болдог, хүний сүнснийг нь зайлуулж болдог гэсэн сүнсний тухай ойлгогдохууны тусгал болно. “Элээ андай”-н үүслийн домгуудод элээ охид бэрээдэд наалдаж андай өвчин олгодог гэж домоглодог. Энэ нь үнэндээ элээ охид бэрээдийн сүнснийг нь зайлуулаад өөрөө тэдний бид оршиж наалддаг гэсэн ойлголт болно. Андай өвчин олж өнгөрсөн гэрэл: “Тэр үед хурим хуй хийвэл дээдэст нь мөргүүлэх учиртай юм. Үхээр онгон (хүүр) бологчид нь мөргөх таширам нэг охин хүн, нэг эм хүний сүнс зам дундаас намайг олзолж гэнэ. Нэг нь манай ой лам (садныхан нэр)-ын нааж эгч, нэг нь энэ гэрийн авга эх, байм эрт үхээд газраа олохгүй, төрөл олохгүй сүнс түйдэж гэнэ”¹⁸ гэж ярив. Хүрээний Маш бөө: “Андай бол сүнсэн өвчин, андай олсон эмийн төрөл садан ба танил хүн, эсхүл үзүүргүй тоосон хүн нь үхвэл, тэр сүнс нь энэ эмд ирж төрөх гээд ирж түйдэж гэм болгоно”¹⁹ гэж ярив. Үүнд хэдийгээр бурхны шашны төрөл олох, төрөл арилжих сүнсний орчилын ухаан илэрч байгаа боловч эчнээ цаана нь хүн үхэвч сүнс нь үхэхгүй. Хүний сүнснийг зайлуулж болдог. Сүнс өөрөө бусдад наалдаж болдог гэсэн балар эртний сүнсний тухай ойлголт илэрч буй. Андайн зарим домогт, Андайчин гэх нэгэн дууч андай дуулах аргаар хүнийн биед элээ шингээх бөгөөд мөн “Элээ дуулах” аргаар хүний биед наалдуулсан элээгээ салгаж чаддаг. Иймээс андай өвчин олсон хүн эрхбиш энэ андай дуулагчийг залдаг гэж домоглодог²⁰. Тус домогт, хүний сүнснийг

¹⁷⁾ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 183-р тал.

¹⁸⁾ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 118-р тал.

¹⁹⁾ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 125-р тал.

²⁰⁾ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 7-р тал.

зайлуулаад оронд нь бусад сүнснийг наалдуулан оршуулж болдог гэсэн балар эртний сүнсний тухай соёл ухамсар илэрнэ.

Балар эртний хүмүүсийн сүнсний тухай ойлгогдохуун нь бөөгийн шашны үед хүрээд нэн илүү хөгжлөө олов. Бөөгийн шашны үзэхээр хүн бол гурван сүнстэй. Бөөгийн шашны гурван сүнсний тухай эрдэмтэд адил бусаар тайлбарлацгааж буй. Юу ч гэсэн хүний сүнсний тухай ойлгогдохуун бөөгийн шашны үед хүрээд гурваар тогтворжсон байна. Гэхдээ чухам ямар гурван сүнс гэдэг нь нэгдэлгүй байдгаас үзэхүл сүнсний тус биеийнхэн тухай ойлгогдохуун маш будлиантай байсныг харуулна. Юу ч гэсэн бөөгийн шашны үзэлтээр хүн бол гурван сүнстэй юм байна. Андайд бөөгийн шашны энэхүү гурван сүнсний тухай ухамсар тусгагдана. Андай гаргах үед:

Нэг нэр болохгүй

Хоёр нэр нэмнэ

Гурван нэр бүрдэхгүй бол

Гаргах андай бүтэхгүй²¹ гэж дуулдаг. “Гурван нэр нь даруй хүний гурван сүнсний бэлгэдэл”²² болно. “Ардын дуунд андай өвчний шалтгааны үндсийг сүнсний хорлол, ад чөтгөрийн наалдвар, увидастай хүний үйл зэрэг байгалиас давсан хүчний нөлөөлөл, үр дүн гэж тайлбарладаг”²³.

Монголчуудын сүнсний тухай ойлгогдохуун нь балар эртний үе, бөө мөргөлийн үе, бурхан шашны үе гэж хувирч ирсэн түүхтэй. Энд бид сүнсний тухай ярихад урьдаар чөтгөрийн тухай яримаар байна. Учир нь чөтгөрийн тухай ойлголт нь сүнсний тухай ойлгогдохууныг нэн бүрэн болгосон байдаг.

Балар эртний хүмүүсийн сүнс бол үхдэггүй, хүмүүсийн бие үхэвч сүнс нь харин үхдэггүй гэх сүнсний тухай ойлгогдохуунийн суурин дээр сүнсний онцгой нэгэн хэлбэр болох чөтгөр буй болов. Балар эртний хүмүүс хүн үхвэл сүнс нь чөтгөр болно гэж үздэг. “Язгуур шашин суртахууны үзэлтэй хүмүүст авч хэлбэл, хүн үхсний дараа хамаг тэргүүний илрэлийн хэлбэр бол чөтгөр болно”²⁴. “Хүмүүс хэдийгээр чөтгөр бол хүний сүнс гэдгийг зөвшөөрдөг боловч тэр нь ирж очихдоо бие сүүдэргүй, гэвч хүмүүс ер нь түүнийг хүний онцлогоор холбон сэтгэдэг”²⁵. Андайд эртний монголчуудын чөтгөрийн тухай ойлголт жич чөтгөрийн орших орны тухай ухамжлал, танилт ойлгогдохуун илэрдэг. Андайд, андай өвчин бол ад чөтгөрийн хорлолоос болов гэж үздэг. Өөрөөр хэлбэл, үхсэн хүний сүнс нь ад чөтгөр болоод хүмүүст наалдан андай өвчин хүртээдэг гэж үздэг. Андайд:

Хэн хүний сүнс буй?

Хүүхэнтэй ямар холбоотой буй?

Хилс амссан учир уу?

Хэргийн үндсээ хэл дээ!

Аль газрын сүнс буй?

Ангаахайтай ямар холбоотой буй?

Амин их зарга уу?

²¹ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 381-р тал.

²² Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 199-р тал.

²³ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 202-р тал.

²⁴ Шүхуа лун: “Дундад улсын чөтгөрийн соёл”, Шанхайн утга урлагийн хэвлэлийн хороо, 1990, 21-р тал.

²⁵ Жан жин: “Чөтгөрийн үзэгдэл”, Даляны хэвлэлийн хороо, 1990, 15-р тал.

Амьдралын бага маргаан уу?²⁶ гэж дуулдаг. Хилс амссан, амин их заргатай сүнс ангаахайд наалдан андай өвчин олгосон байжээ. Үүнд хилсээр үхсэн, амин заргатай үхсэн хүний сүнс нь чөтгөр болдог гэсэн ойлголт илэрч буй. Хүн үхсний сүүлээр сүнс нь чөтгөр болж түүний энэ дэлхий дээр амьдарч байсан үеийн хамгийн илүү тоож хайрласан, хамгаас илүү бодож санасан эсхүл хамгаас илүү хорсч занасан хүндээ наалдан оршиж өөрийнхөө бодож санаснаа илтгэх буюу өшөө хорслоо авдаг гэж балар эртний хүмүүс ойлгодог. Үүнийг андайн ойлголтоор хэлбэл, андай өвчин олгодог байжээ. Андай өвчин олсон гэрлийн хэлсэн “нагац эгч, авга эхийнхэн сүнс” түйтэж андай өвчин олгосон, Маш бөөгийн хэлсэн “төрөл садан ба танил хүн, эсхүл хязгааргүй тоосон хүнийхэн сүнс нь түйдэж иймэрхүү гэм болгодог” гэх зэрэг яриа бол даруй иймэрхүү ойлгогдохууны илрэл болно. Андайд:

Шаахайнаас чинь цаадах нь хө

Шаамал элээний биен жиан (хязгаар газар гэх утгатай)

Шаахайнаас чинь наадхи газар

Шагжамүн манай бян жиэн²⁷ гэж дуулдаг. Үүнд чөтгөрийн оршиж байгаа орныг “шаахайнаас чинь цаадах” гэв. “Шаахайнаас чинь цаадах” гэсэн нь газар доорхи орон болно. Энэ нь бөөгийн шашны ертөнцийн үзэлтэй тохиролцож буй. Бөөгийн шашны үзэлтээр ертөнцийг дээд, дундад, доорд гэж гурван давхар хуваадаг. Дээд ертөнц бол ариун сайхан, энэрэнгүй ертөнц бөгөөд дундад ертөнцийг аливаа гаслан зовлонгоос хамгаалж, доод ертөнцтэй үргэлж дайн дажин хийж байдаг. Дундад ертөнц дээр хүн амьтан оршиж амьдарна. Харин дундад ба доорд ертөнцийн хооронд нэгэн үл мэдэгдэх ертөнц буй бөгөөд хүн үхвэл голдуу энэ ертөнцөд очно. Доорд ертөнц дээр хүүрийн шулмаснууд хуран сууж, аливаа өвчин тахлыг тархаагч бүхэн ад хуралдана. Энэ бол тамын орон мөн²⁸ гэдэг. Бөө мөргөлийн энэхүү гурван ертөнцийн үзэлтээс үзэхүл, дундад ба доорд ертөнцийн хооронд бас нэгэн үл мэдэгдэх ертөнц байгаа бөгөөд хүн үхбэл сүнс нь чөтгөр болоод тэр даруйд нь доорд ертөнц буюу дээд ертөнцөд очдоггүй харин энэхүү үл мэдэгдэх ертөнцөд очдог байжээ. “Чөтгөр бол хүүр биеийг оршуулсан хүүр онгонд сууж, газар доор байдаг”²⁹. Хүүр онгон нь яг саяхан дундад ба доорд хоёр ертөнцийн хооронд байж, үл мэдэгдэх ертөнцөд харьяалагдана. Хүмүүст андай өвчин олгодог андай чөтгөр буюу муу сүнс бол үхээд төрөл олохгүй байх буюу орших газраа олохгүй тэнүүчлэн хэсч байгаа сүнс болно. Эдгээр сүнс чөтгөр бол голдуу дундад ба доорд ертөнцийн хоорондох үл мэдэгдэх ертөнцөд оршиж байдаг. Энэхүү үл мэдэгдэх ертөнцийг бас “зуурдын орон” гэдэг. Үхсэн хүний эргэж төрөх төрөл олсонгүй тийм сүнсийг “зуурдын сүнс” гэдэг. Тэгэхлээр “зуурдын орон” гэдэг нь тэнэмэл сүнсийн ертөнц гэсэн утгатай³⁰. Энэхүү “зуурдын орон” нь хүүр онгон буюу хээр хөдөө эсхүл буйд бөглүү, тачир хоосон, намаг шалбаагтай, ган хагсарган их, цас мөстэй зэрэг байгалийн аюул гамшигт орон байдаг. Андайд:

Чавгатайгаас цагаадай нь даа

Цастай мөстэй таны орон шүү

²⁶ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 381-р тал.

²⁷ Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 371-р тал.

²⁸ Ч.Далай: “Монголын бөө мөргөлийн товч түүх”. Вансанжав, Чойралжав нар буулгав. Тосон дармал. 26, 71-р тал.

²⁹ Лин жа лин: “Чөтгөрийн ертөнц-Дундад улсын уламжлалт соёл доторх чөтгөрийн тухай танилт”, Шямэн их сургуулийн хэвлэлийн хороо, 1993, 135-р тал.

³⁰ Г.Буянбат: “Монголын бөөгийн шашны учир”. Өвөрмонголын хэвлэлийн хороо, 1985, 85, 86-р тал.

Чавгатайгаас наадтай нь даа
Цагаан гэгээн манай орон шүү
Намагтайгаас цагаатай нь даа
Нустай цустай нь таны орон шүү
Намагтайгаас наадтай нь даа

Нартай сартай манай орон шүү³¹ гэж дуулдаг. Андай өвчин олгодог ад чөтгөрийн орон нь цастай мөстэй, цустай нустай аймшигт орон байжээ. Энэхүү орон нь цагаан гэгээн, нартай сартай хүний ертөнцтэй ил тод харьцуулал болж буй. Энэ бол балар эртний хүмүүсийн байгалийн нууцыг ойлгож ядан, их байгалийн аюул гамшгаас айн сүрдэхдээ эдгээр орон бол ад чөтгөрийн орон, ад чөтгөр бол иймэрхүү оронд л сая оршин орогнодог гэсэн ойлголт болно.

Хураангуйлбал, андайд балар эртний хүмүүсийн сүнс болон сүнсний онцгой нэгэн хэлбэр болох чөтгөрийн тухай ойлгогдохуун бодитой илэрнэ.

Дөрөв. Дом шүтлэг

“Хүрээ андай товчоо” гэх номонд, андай гаргах үеийн элээн дом шившлэгийн зан үйлийг нарийн тайлбарлав.

Андай гаргахдаа заавал зүүн зүгийг сонгож, “Цагаатай нь чивэлтийн орон, наадтай нь нартын ертөнц”-ийн зааг гэж “элээ үүд” босгодог. Үүнд, таван алдын зайтай хоёр үзүүр багана босгож олсон дээсийг татаж уяна. Цаана нь андай хүүхний хайртай хувцас хунар засал чимгээр хувцаслаж чимэглэсэн өвс, бургас, сухай зэрэг зүйлийг зогсооно. Түүнээ “ша-ийн зааг” гэнэ. “Элээ үүд”-ний цаана өргөө цагаан гэрийг хатгаж, бөөгөөс андай хүүхнийг дохиж элээ үүдээр шургуулан өргөө цагаан гэрийг сумдаж унуулна. Андай хүүхэн унангуутаа бөө хонхот ташуураар хэдэт гөвшинө. Андай бүтсэний дараа бөө “элээ гурван элч”-ийн домогт дахь Харсан хаан, Ханга хатан, Харалдай Боролдой, Баянчуудай, Залан дугуй, Усан хайлуур, Элээшар (Элээ шир)-ийн дүрийг гурилаар барьж өмнө нь идээ ундааны зүйлийг өрж, хоёр талд нь зул асааж гадуур нь “хас хот” гэж цагаан цаасан туг ба элээ цагираг татна. Эцэстээ эдгээрээ өргөө цагаан гэрийн хамт шатааж дуусгана³².

Энэ бол нэг зүйлийн дом шившлэгийн зан үйлийн үзэгдэл болно. Дом шүтлэг нь дом шившлэгийн зан үйлээр дамжин биелэгддэг. Дом шившлэг бол хүн төрөлхтний балар эртний шүтлэг бишрэл болон далдын хүчнийг итгэн биширч байсан үзэлт ойлгогдохууны суурин дээр буй болсон зан үйлийн үзэгдэл болно. Дом шившлэг бол хүн төрөлхтний утга урлаг, шашин суртахуун, соёл ухамсрын үүслийн чиг, язгуур хэв болно. Фрэйзер “Алтан гишүү” гэх номдоо хүн төрөлхтний соёл ухамсрын хөгжилтийг “дом шившлэг - шашин суртахуун – шинжлэх ухаан” гэж тайлбарлаж өнгөрөв. Дом шившлэгийг ажил үйлийн дом шившлэг, амьдрал ахуйн дом шившлэг, эмчилгээ заслагын дом шившлэг зэрэг хэдэн төрлөөр анхлан үздэг³³. Андай бол “андай өвчин”-ийг засахад зориулан хийдэг дом шившлэгийн зан үйлийн үзэгдэл болохоор эмчилгээ заслагын дом шившлэгт харьяалагдана.

Язгуур эртний хүмүүс хүний өвчнийг засахдаа “эмээр засах”, “домоор засах” хоёр зүйлийн заслагын аргыг хэрэглэж байжээ. Тухайн үед, эм эмнэлэгийн үйлс хөгжөөгүй

³¹) Начиншонхор: “Андайн соёл судлал”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2001, 373-р тал.

³²) Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андай товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 202-р тал.

³³) Мандах: “Ардын аман зохиолын онол”. Лионнингийн үндэстний хэвлэлийн хороо, 2003.

учраас “дом заслага” нь тухайн үеийн хүмүүсийн шүтлэг бишрэл, сүнсний тухай ойлгогдохуунтай уялдаад нэн түгээмэл хэрэглэгдэж байв. “Дом заслага” бол дом шившлэгийн нэг төрөл зүйл, эмчилгээ заслагын дом шившлэг болно. Балар эртний үед, тусгай дом заслага хийдэг домч байжээ. Балар эртний үеийн өвчин заслагад эмээр засах болон домоор засах хоёр зүйлийн арга нь уялдан нэгдээд явагдаж байсан төлөвтэй. Хүмүүсийн ердөө хэлдэг “эм дом” гэдэг нь “эмийн заслага” болон “дом заслага” хамтдаа явагдаж байсан балар эртний хүмүүсийн эмчилгээ заслагын тусгал гэмээр. Андайдах балар эртний хүмүүсийн дом заслагын зан үйл соёлын үзэгдэл голдуу андайн язгуур хэлбэрийн нэг болох “элээ андай”-д илэрдэг. “Хорчинчууд элээг ад гэж үзэн, элээ хайчилж шатааж уулгадаг буюу зунгаг усанд хийж гээн өвчинтэй хүнд дом заслага хийдэг. Элээ хайчлахдаа таван элээ долоон элээ, есөн элээ гэж эр эм хүйсийн ялгалтай хайчилна. Хайчилсан элээ нь гараа холбосон хүний дүртэй”³⁴ байдаг. Энэ бол даруй эртний хүмүүсийн дом заслагын соёлын үзэгдэл болно. Балар эртний хүмүүсийн дом заслагаар дамжин хүнд андай өвчин олгож байсан элээ адыг үлдэн хөөж байжээ. Үүнд, эртний монголчуудын тооны шүтлэг (3, 5 мэт өрөөсөл тоог шүтэх) үг хэлний шүтлэг (элээ андайд элээ адыг хөөхдөө хэлдэг) “элээний явдал гэгч есөн эхтэй юм шүү”, “элээний явдал гэгч арван зүйлийн эхтэй шүү” гэх мэтээр дуулан хэлдэг нь үг хэлэндээ түшиглэн ад чөтгөрийг үлдэн хөөж байсны илрэл болно), амьтны шүтлэг (элээг шүтэх) зэрэг олон зүйлийн шүтлэгийн органик уялдал илэрч буй. Фрэйзер дом шившлэгийг буй болсон үзэл санааны үндэс ба домнох арга хэлбэрээр нь “дүрэмлэх дом” (бас дуурайх дом гэдэг) болон “хүртээх дом” (бас халдаах дом гэдэг) гэж хоёр зүйлд хуваан үзэв. Цаасаар элээ хайчилж шатаах дом бол даруй “дүрэмлэх дом” болно. Дээрхи зан үйлийн сийрүүлэлд тэмдэглэж байгаа “андай хүүхний хайртай хувцас хунар засал чимгээр хувцаслаж чимэглэсэн өвс, бургас, сухай” зэрэг бол дүрэмлэх дом болон хүртээх дом уялдан хэрэглэгдэж байгаа үзэгдэл болно. Үүнийг бас “золиг гаргах” гэж хэлдэг. “Элээний дүрийг гурилаар барьж өмнө нь идээ ундааны зүйлийг өрж, хоёр талд нь зул асаах” бол дүрэмлэх дом болох бөгөөд балар эртний хүмүүсийн амьтны шүтлэгийн зан үйл болох элээ шүтлэгийн соёл үзэгдэл болно. “Эртний хүмүүсийн өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд аливааг дуурайн дүрсэлж үйлдэхийг чухалчилдаг ба энэхүү дуурайн дүрслэх үйлдэл болон түүнээс хүсэн хүлээх үр дүн хоёр нь шалтгаан үрийн шууд холбоотой гэдэгт итгэдэг байжээ”³⁵. Балар эртний хүмүүсийн иймэрхүү “ижил шалтгаанаас ижил үр тогтох” гэдэг ойлгогдохууны үндэслэл дээр буй болсон домьг “дүрэмлэх дом” (дуурайх дом) гэдэг. Балар эртний хүмүүсийн нэг юмын хэсэг тал буюу түүнтэй хөндөж хүрэлцэж өнгөрсөн юмаар тэр юмыг нөлөөлж чадна гэж үздэг ойлгогдохууны суурин дээр буй болсон домьг “хүртээх дом” (халдаах дом) гэдэг. Сухай, бургас зэргээр хүүхний дүрсийг дууриан үйлдэх бол дүрэмлэх дом, хүүхний өмсөж өнгөрсөн хувцсыг түүнд өмсгөн шатааж орхих бол хүртээх дом болно. Цаасан элээ хайчилж өвчиндөө шатааж уулгах буюу гээж орхих, элээний хөргийг шүтэн тахих буюу золиг гарган шатааж гээвэл ад чөтгөр аяндаа нь зайлж өвчтөний өвчин нь илэрхий болно гэж балар эртний хүмүүс итгэдэг байжээ. “Элээ андай”-н бүжгийн хөдлөлд элээний эргэхийг дуурайж бүжиглэсэн хөдлөл буй. Энэ бол мөн ч эртний хүмүүсийн дүрэмлэх домьн соёл үзэгдэл болно.

³⁴ Саруул эрхлэн найруулав: “Хүрээ андаа товчоо”. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 2012, 90-р тал.

³⁵ Тайлур: “Баларлиг үеийн соёл”. 1871, С.Дуламын “Монгол аман зохиолын онол”-оос дам ишлэв. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2009, 111-р тал.

Тав. Бөөгийн шүтлэг

Бөө мөргөл бол шашин суртахууны анхны уугуул хэлбэр болно. Фрэзер “Алтан мөчир”-төө саманы (бөө мөргөл) шашны суурин дээр шашин суртахуун буй болов гэж үзэв. Эртний монголчуудын байгалийн шүтлэг, тотем шүтлэг, дээдсийн шүтлэг зэрэг шүтлэгийн суурин дээр бөө мөргөл гэх шашин шүтлэгийн үзэгдэл буй болов. Бөө мөргөл буй болсон нь эртний тэрхүү тархай бутархай, олон янз, өөр өөрийн онцлог бүхий иргэний шүтлэгнүүд нь оргиникаар нэгдээд нэг нийтээр журамлах зохион байгуулалттай, нэгдсэн шүтээнтэй, нийтлэг зан үйлтэй, тогтсон ертөнцийн үзэлтэй шашны үзэгдэл монголчуудын дунд буй болсныг харуулж буй. Бөө мөргөлийн хамаг дээд шүтээн бол мөнх тэнгэр болно. Бөө мөргөл нь ертөнц бол дээд, дунд, доорд гурван давхаргаар бүтлээ гэж үздэг. Бөө мөргөлд тэнгэр тахих, овоо тахих, гал тахих, шанши мод тахих зэрэг нийтлэг зан үйлтэй. Манай ярьж байгаа андай нь монголчуудын бөө мөргөлийн шүтлэгтэй шууд холбогдоно. Судалгааныг үндэслэвэл, андай бол эхийн эрхт овог төрлийн нийгмийн үед үүссэн бөгөөд бөө мөргөл нь ч энэ үед үүсэв. Хүн төрөлхтний хөгжилтийн түүхэн дээр эхийн эрхт овог төрлийн байгуулал нь урт хугацаа явагдсан байдаг. Энэхүү урт хугацааны дотор хүмүүсийн шүтлэг бишрэл, соёл ухамсар маш их хувиралт хөгжилттэй байж байгалийн шүтлэгээс шашны шүтлэг болсон хөгжилтийн явцыг дамжжээ. Андай (хэдийгээр тухайн үед бас андай гэж хэлдэг эсэх нь магадлаж чадахгүй боловч иймэрхүү соёлын хэлбэр байжээ)-д бөө мөргөлөөс өмнөх үеийн балар эртний хүмүүсийн амьтан ургамалын шүтлэг, сүнсний шүтлэг хадгалагдаж байгаа бөгөөд хүн төрөлхтний хамаг анхны бүжиг дуу (амьтныг дуурайх бүжиг дуу), үг хэлний урлаг (андайн үг), өвчин заслага (дом) зэрэг соёл урлагийн хэлбэрүүд хадгалагдаж байдаг. Иймээс андай бол бөө мөргөлөөс өмнөх үеийн балар эртний монголчуудын иргэншлийн хэлбэр бүхий онцгой нэгэн нийлэг соёлын үзэгдэл болно. Онцгойлон андайн алс эртний язгуур хэлбэр гэгдэж байгаа “ад андай”, “элээ андай”-д энэхүү үзэгдэл нэн тод илэрнэ. Бөө мөргөл буй болсны дараа андай гэх энэхүү язгуур соёлын үзэгдлийг эзэрхэн эрхшээж тусгайлан бөө удган нар андайг даачлан явуулж андай өвчнийг засах болов. Ингээд иргэншлийн хэлбэртэй байсан соёлын үзэгдэл болох андай нь шашны ёслолын хэлбэртэй болж тусгай өвчин засдаг болов. “Хүрээ андай товчоо” гэх номд, андайд бөө мөргөл хэрхэн холбогдож ирсэн учир шалтгааныг доорхи хэдэн талаар шинжлэв:

Нэгд, андайг бөө таачлан явуулдаг бөгөөд андай өдөөх ба гаргах ёслолыг бөө биеэрээ эрхлэн хийдэг.

Хоёрт, андайд голдуу бөө мөргөлийн өвчин заслагад зориулан явуулж байв.

Гуравт, бөө мөргөлийн үзэлтээр бол андай суудалтай.

Дөрөвт, андай дуулахад хэрэглэх хонх ташуур бол бөөгийн шүтлэгийн нэг бэлэг тэмдэг болно.

Тавд, бөөгийн шашны нөлөөн доор ардын бүжиг байсан андай нь шашны бүжиг болж хувирав.

Долоод, орон нутгийн онцгой газар зүйн орчин болон өвөрмөц улс төрийн нөлөөллөөс болж бөө мөргөл нь хорчин, хүрээ, монголжинд үлдэж ирэхийн хамт андай ч эдгээр орон нутгаар үлдээгдэж ирэв. Үүнд онцгойлон хүрээ хошууны онцгой төр засгийн байгууламж болон газар зүйн нөхцөл, хүн амын бүрэлдэл нь орчин үед хүрээ хошуунд андайн шинэ хөгжлийг буй болгов.

Үүнээс үзэхүл, андайн соёлд бөө мөргөлийн шүтлэг нуруувч болон хадгалагдаж ирэв. Андайн анх эхэндээ ард иргэний соёл урлагийн үзэгдэл байснаасаа хожим нь бөө мөргөлд эрхшээгдэн бөө мөргөлийн өвчин засах арга хэлбэрийн нэг болж хувирав. Андай бөө мөргөлийн хувиралт хөгжилтийг дагалдан хувиран хөгжиж ирэв.

Ерөнхийд нь хэлбэл, андай бол уудлаад баршгүй соёлын үнэ өртөгтэй, идэвхич ач холбогдолтой гайхамшигт сайхан соёлын бүтээгдэхүүн болохоор барахгүй эрхбиш судлан шинжилж, уламжлан залгамжилж, хамгаалан хөгжүүлэх чухалтай бодисын бус соёлын нандин өв болно. Монгол үндэстний энэхүү өвөрмөц мөртөө өнгө ялгарам нэг багц соёлын цэцэг бол балар эртний монголчуудын амьтны шүтлэг, модны шүтлэг, сүнсний шүтлэг, дом шүтлэг, бөөгийн шүтлэг зэрэг олон зүйлийн шүтлэг бишрэлийн соёлын хөрс шороо дээр урган цэцэглэж, эдгээр шүтлэг бишрэлийн соёлын органик нэгдлийн суурин дээр хөгжин хувирч ирсэн олон ишт нийлэг шинж бүхүй соёлын үзэгдэл болно. Андай бол монголчуудын балар эртний шүтлэг бишрэлийг манд сонордуулан гайхуулж, харуулан мэдүүлж байгаа язгуур соёлын ачаалагч мөн.

ABSTRACT

Dance ritual is a valuable intangible culture among Mongolian nationalities. Different cultural traces and types penetrated into the dance rituals of Mongolian ethnics. In this article, the author discusses the cultural rituals of animals, trees, soul, remedies and shamanic worship which included in the dance rituals in ancient Mongolian culture.

From the cultural content, dance rituals kept different cultural traces of ancient folklore, literature, songs, dances, medicine, religion, rites, cultural conception and consciousness of the Mongolians. From the scientific aspect, dance rituals has been connected to the studies on art and literature, social and cultural anthropology, ethnology, theology, human and cultural geography, science of medicine so on. Therefore, dance ritual is one general aspect of cultural heritage. Studying the cultural aspects in dance rituals will be significant to the studies on Mongol culture.